

“АХМАДЫН ХОТХОН-1” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН  
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016 оны 06 дугаар сарын 20

Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүн

- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн Хөтөлбөр батлах тухай 9/36 тоот тогтоолыг хэрэгжүүлэн, 2016 оны эхний хагас жилийн байдлаар Сонгон шалгаруулах коммисын шийдвэрээр эрхийн бичиг авсан 8 ахмад настантай гэрээ байгуулан, нийт 293 айл өрх тус хотхоны орон сууцанд тав тухтай амьдарч байна.
- Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Нийслэлийн мэдээлэл технологийн газраар тус газрын цахим хуудсыг [www.akhmadiinkhotkhon-1.ub.gov.mn](http://www.akhmadiinkhotkhon-1.ub.gov.mn) хаягаар хийлгэж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг цаг тухайд нь байршуулж, [www.shilendans.gov.mn/main/agency/10289](http://www.shilendans.gov.mn/main/agency/10289) гэсэн шилэн дансны цахим хуудсаар төсвийн хөрөнгийн захиран зарцуулалт, санхүүгийн ил тод байдлын тухай мэдээллийг оруулан иргэд олон нийтэд ил тод мэдээллэж байна.
- Сар шинийн баярыг тохиолдуулан тус газрын даргын 2016 оны А/02 тоот тушаалаар Ахмадын хотхон-д амьдарч буй харж хандах хүнгүй, ганц бие 7 ахмад настанд хадаг, тавгийн идээг гардуулан өгч хүндэтгэл үзүүллээ.



- Сар бүрийн 20-ны өдөр тус хотхоны оршин суугчдын хөдөлгөөний мэдээллийг нийслэлийн Захирагчийн ажлын албанд хүргүүлэн ажиллаж байна.
- Тус хотхоны иргэд оршин суугчидтай давхар, давхарт нь хурал зохион байгуулж, байгууллагын 2015 оны үйл ажиллагааг тайлагнаж, давхар тус бүрт дарга томилон хөршийн холбоог сайжруулан, санал хүсэлтийг хүлээн авч ажиллав.
- Шинээр баригдаж буй 132 айлын “Халамжийн орон сууц”-ыг хүлээж авахтай холбогдуулан “Баярс констракшн”-ны инженерүүдтэй хогийн функер, тагт болон тохижилтын талаар уулзаж, саналаа солилцлоо.



- Бэрэн констракшнтай хамтран хүчтэй салхины улмаас байруудын пасадны унасан хэсэг болон 2 байруудыг фасадыг бүрэн бэхэлж тогтоох ажлыг зохион байгууллаа.



Хоёр. Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үр дүн

- Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг тухайд нь хийж гүйцэтгэн, үүрэг даалгаварын биелэлттэй холбоотой мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээллэж байна. Тухайлбал Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаварын хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээний өдрөөр хотхоны байруудын гадна 600м2 талбайд их цэвэрлэгээ хийж, орц, үүдний хэсгийн хана, шатыг сэргээн засварлаж, будаж тохижуулсан.



- Сар шинийн баяр амралтын 2016 оны 02 дугаар сарын 09-нөөс 11-ний өдрүүдэд газрын даргын 2016 оны А/03 тоот тушаалаар хариуцлагатай эргүүл томилон ажиллуулж, Шуурхай мэдээллийн төвд хотхоны үйл ажиллагааны талаар өдөрт 3 удаа мэдээллэж, баяр амралтын өдрүүдийг тайван өнгөрүүллээ.
- Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургалтыг 901-р байрны 1 давхарт байрлах үйлчилгээний зориулалттай Эмийн сан, Хүнсний мухлаг, оршин суугчидтай хамтран зохион байгуулж, нийт 19 гаруй хүн оролцов. Мөн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх зааварыг тус хотхоны 2 байруудын давхруудад байршуулж, иргэд оршин суугчдад мэдээллэсэн.
- Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 07-ний өдрийн Уриалга хүргүүлэх тухай 2/900 дугаар албан бичгийн дагуу байгууллагын хаяг, өнгө үзэмжийг сайжруулах, ногоон байгууламжийн арчлалт, нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттайгаар явуулж, гаднах орчны нийтийн их цэвэрлэгээг сар бүр зохион байгууллаа.
- Мөн Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 02/06 дугаар албан даалгаврын хүрээнд 05 дугаар сарын 15-ний өдөр тус хотхоны урд талбайг шинээр тохижуулан 10ш улиас, зүүн талд 5 улиас мод, 250ш цэцэг нэмж суулгах ажлыг хийж гүйцэтгэлээ.






- Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2016 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 6/3811 дугаар албан бичгээр тус хотхоны тоглоомын талбайг зөөлөн резинен хавтангаар хучих хүсэлтийг зөвшөөрсөний дагуу Шимфреш ХХК-тай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан 40мкв талбайг тохижуулах ажлыг гүйцэтгэж байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион явуулах ажлын хүрээнд газрын даргын 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/08 дугаар тушаалаар Байгууллагын үзлэг тооллогын комиссыг томилон, урьдчилсан үзлэг, тооллого явуулж, эд хөрөнгийг дугааруудыг шинэчилэв.
- Хотхоны байруудын орцны явган шат, цахилгаан шатуудыг камержуулж, харуул хамгаалалтыг сайжруулан, иргэд оршин суугчидын аюулгүй байдлыг ханган ажиллаж байгаа бөгөөд гэмт хэргийн шинж чанартай 2 үйлдэлийг илэрүүлж, 10 гаруй хэргийн бичлэгийг цагдаагийн ажилтан албан хаагчид хуулж, дэмжлэг туслалцаа үзүүлснээр иргэд оршин суугчид болон тус хэсгийг хариуцсан цагдаагийн албан хаагчдаас сайшаал хүртээд байна.
- Байруудын орцны гадна хаалга салхи цохин хүчтэй савж хаагддагаас болж хаалганууд хөдөлгөөн орсныг засварлан, шил хагарсанг шиллэж хэвийн болголоо.

#### Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

- Нийслэлийн Засаг даргатай 2015 онд байгуулсан Үр дүнгийн гэрээг 86 хувь хангалттай сайн дүгнүүлэн, 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, нийслэлийн Засаг даргатай 2016 оны Үр дүнгийн гэрээг байгуулав.
- Нийслэлийн Өмчийн харилцааны газраар байгууллагын 2016 оны Бизнес төлөвлөгөөг батлуулж, Контракт гэрээ байгуулав.
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй байгуулсан тусгай зөвшөөрлийн гэрээний хугацаа дууссан тул гэрээг дүгнүүлж, холбогдох материал, судалгааг хүргүүлэн, хамтран ажиллах гэрээ байгуулсан.
- ХСУХАТАҮЗЗ-өөс “Ус ба ажлын байр” гэсэн уриан доор 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан хэлэлцүүлэгт тус газрын Ерөнхий инженер оролцов.

- Нийтийн үйлчилгээний “Улаанбаатар нэгтгэл” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай хог тээвэрлэх гэрээнд сунгалт хийв.
- Улаанбаатар лифт компаниар хотхоны 4 лифтны засвар үйлчилгээг тогтмол хийлгэж, хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.
- “Ахмадын хотхон-1” ОНӨААТҮГ-ын даргын нэрэмжит “Хаврын ээлжит техникийн үзлэгийг 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 04 дүгээр сарын 14-ний өдрийн хооронд Хотхоны барилга байгууламж, гадна талбайн тохижилт, цэвэрлэгээ, айл өрхийн дулаан, цахилгаан, цэвэр бохир усны шугам сүлжээ, гэрэлтүүлэг, цахилгаан шат, УДДТөв, дулааны узель, автограж, галын гидрант, салхивч, гадна дулаан, халуун хүйтэн ус, бохир усны шугам, худагт үзлэг шалгалтыг тус газрын инженер техникийн ажилтнууд явуулав.
- Улаанбаатар дулааны сүлжээ ХК-аас ирүүлсэн 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 1-15 дугаар албан шаардлагын дагуу тус байгууллага нь шинээр ашиглалтанд орох 132 айлын орон сууцыг хүлээн авахтай холбогдуулан дулааны узельд байрлах өргөлтийн 2 насосыг UPS-65-180F /380W/ маркийн холигч насосоор солих ажлыг хийж гүйцэтгэн, өвөлжилийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
- Оршин суугчдын буруутай үйлдлээс болж угаалтуур, суултуур бөглөрөх, инженерийн шугам сүлжээнд бага зэргийн гэмтэл гарах зэрэг асуудлууд байнга гарч байсан тул дуудлагаар очсон засварчид тухайн айлдаа засвар үйлчилгээ үзүүлж, заавар, зөвлөгөө өгч ажиллаж байна.
- УДДТөв, гадна шугам сүлжээ, хотхоны байруудын халаалт, халуун хүйтэн ус, ариутгах татуурга зэрэг инженерийн шугам хоолойтой холбоотой 257 дуудлага ирсэний дагуу инженер техникийн ажилчдаар засвар үйлчилгээг хийж барагдууллаа. Үүнээс холигч 65, уян 22, ванн жорлонгийн бөглөрөл хөвүүр сольсон 47, винтель сольсон 53, паар халахгүй доголдсон 24, ус алдсан 46 дуудлага ирсэн байна.
- Тус хотхоны 901 дүгээр байрны салхивчны хоолой хүчтэй салхинд нурж, эвдэрснийг Бэрэн констракшнаар янзлууллаа.



- Байруудын дээврийн хар цаас цоорж, айлуудын дээрээс ус гойжиж байсныг шинээр хар цаас тавьж засварласан.
- Хотхоны байруудын ариутгах татуурын шугам хоолойн хог шүүгчийг сар бүрийн 10, 25-нд тогтмол цэвэрлэж, 2 удаа хог шүүгчийг шинээр сольсон бөгөөд ариутгах татуургын шугам хоолойн бөглөрлөөс урьдчилан сэргийлж ажиллаж байна. Мөн Зөгийн үүр барилгын материалын дэлгүүрийн баруун талд байрлах

ариутгах татуургын 6 дугаар худаг бөглөрснийг газрын бие бүрэлдэхүүн шуурхай ажиллан бөглөрлийг гарган хэвийн ажиллагаанд оруулав.

- Хотхоны байруудын хогийн бункерын бөглөрлийг 12 удаа гаргаж, 7 хоногийн Лхагва гараг бүр Нийтийн үйлчилгээний Улаанбаатар Нэгтгэл ОНӨААТҮГ-ын тусгай тоноглолтой автомашинаар ачилт хийлгэж байна.
- Хотхоны дулаан гражид түр хугацаагаар автомашин тавиулах гэрээг 2 албан байгууллага, 15 иргэнтэй байгуулан ажилласан.
- “АХМАДЫН ОРОН СУУЦ”-ыг тусгай нөхцөлтэйгээр хөлслүүлэх гэрээний хугацаа дууссан 264 айлын гэрээнд сунгалт хийж, 7 төрийн албан хаагчтай шинээр “Ахмадын орон сууц”-ыг тусгай нөхцөлтэйгээр хөлслөх гэрээ байгууллаа.
- Байгууллагын 2015 оны үйл ажиллагаанд хөтлөгдсөн 39 баримт бичгүүдийг цэгцлэж, үдэж, хавтаслаж, архивт хүлээлэлцэх ажлыг зохион байгуулав.

#### Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

- Байгууллагын цахим хуудас [www.akhmadiinkhotkhon-1.ub.gov.mn](http://www.akhmadiinkhotkhon-1.ub.gov.mn) сайтад үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цаг тухайд нь тайлагнан, байгууллагын санхүүгийн ил тод байдлыг [www.shilendans.gov.mn/main/agency/10289](http://www.shilendans.gov.mn/main/agency/10289) цахим хуудсыг хөтлөн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Захирамжлалын баримт бичгийг цахимжуулах ажлын хүрээнд байгууллагын даргын 2015 оны 65 тушаалыг нийслэлийн Архивын газрын цахим хуудсанд шивж оруулсан.

#### Тав. Бусад мэдээлэл

- Нийслэлийн харьяа газрууд, агентлагуудын дунд 2016 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан “РИО-2016” цасны баярт тус газрын 8 ажилтан албан хаагч идэвхитэй оролцов.
- Нийслэлийн Захирагчийн Ажлын албанаас харьяа газруудын Архив, бичиг хэрэг, хүний нөөц, дотоод ажил, хууль эрх зүй хариуцсан албан хаагчдын дунд 2016 оны 04 дүгээр сарын 01,02-ны өдрүүдэд зохион байгуулсан “Мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөх” сургалтанд тус газрын гэрээний мэргэжилтэн Г.Батсанааг хамруулсан.
- Нийслэлийн Захирагчийн Ажлын албанаас зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хандивын тоглолтыг байгууллагын 6 ажилтан хаагчийг үзүүлсэн.
- Эх үрсийн баярыг тохиолдуудан ажилтан албан хаагчдын 12 хүртэлх насны 18 хүүхдэд байгууллагаас гарын бэлэг гардууллаа.

Гэрээний мэргэжилтэн:

Г.Батсанаа